

**МОНГОЛ ХЭЛНИЙ ДАВТАХ ЁСНЫ
БҮТЭЦ ХЭЛБЭР, УТГА, НАЙРУУЛГА СУДЛАЛЫН АСУУДАЛД**

Ж.Бат-Ирээдүй*

Давталт буюу reduplication гэх хэлний элемент давтах үзэгдэл бол дэлхийн хэлнүүдэд нийтлэг байдаг зүйл бөгөөд зарим зүй тогтол, гүйцэтгэх үүрэг, утгаараа хэл хэлэнд ойролцоо төстэй ч байдаг байна. Тухайлбал, Хэлшинжлэлийн нэр томъёоны толь бичигт, “Давталт бол үгзүйн үзэгдэл бөгөөд үгзүйн төрөл бүрийн хэсгийг үгийн сан, хэлзүйн янз бүрийн үүргээр давтах явдал байдаг бөгөөд давталт бол дэлхийн олон хэлэнд байдаг нийтлэг үзэгдэл бөгөөд төрөл бүрийн учир зорилгоор давтдаг байна.” (*The morphological phenomenon in which some morphological material is repeated within a single form for lexical or grammatical purposes. Reduplication is a common phenomenon in the languages of the world, taking a variety of forms and serving a variety of purposes.*¹), Аливаа хэлбэрийг хэсэгчилэн болон бүхлээр давтах нь үгзүйн процесс бөгөөд латин хэлний *momordi* гэдэг үгийн *mord* хэмээх эхний үеийг давтаж *mo-mord* гэж давтаж байгаа нь хэсэгчилсэн давталтын хэлбэр юм. (*A morphological process by which all or part of a form is repeated. E.g. the latin stem momord- (in momordi 'I bit') is derived from mord-by reduplication of the initial consonant and vowel: mord- → mo-mord. This is a case of partial reduplication;*²) хэмээн тус тус бичжээ. Жишээ нь, англи хэлэнд *for months and months, for years and years, goody-goody, hugger-mugger, wishy-washy*, гэх мэт, малай хэлэнд *baik – сайн, baik-baik – бүр сайн, bunga-цэцэг, bunga-bunga цэцгүүд, mata-нүд, mata-mata-цагдаа, anak – хүүхэд, anak-anak хүүхдүүд, тагалог хэлэнд tatlo – гурав, tatatlo гэвэл гуравхан гэсэн утгатай болох зэрэг давтсан үг хэллэг (a word, phrase, etc) олон байдаг байна. Дэлхийн олон хэлний давталтын үүргийг ажиглавал олны утга заах, хүч нэмэгдүүлэх, давтах утга заах үүргээрээ төстэй байдаг байна. Гэтэл зарим хэлэнд давталтыг үйл үгийн цаг, үйлээс нэр үг үүсэх, тийн ялгалын хувиргалын үүргээр хэрэглэх зэрэг тохиолдол байдаг байна. Жишээлбэл, Греек хэлэнд *luo* гэвэл хаях гэдэг үгийн одоо цаг, *luo luo* гэж давтвал хаясан гэх тухайн үгийн өнгөрсөн цаг заадаг байна.*

Монгол хэл бол давталтын сонин сонин хэлбэр, бүтэц, загвар арвинтай хэл бөгөөд энэхүү язгуур, үндэс, үг хэллэг давтах үзэгдлийг хэлшинжлэлийн үүднээс үг давталт, давтмал үг, давтац үг, давтах ёс, давтан хоршоо, дууриан хоршоо, цуурай үг гэх мэтээр судлаачид янз бүрээр нэрлэж бичиж тайлбарлаж иржээ.

Харин бид энэ өгүүлэлдээ монгол хэлний давталтын төрөл бүрийн хэлбэр онцлог, зүй тогтол зэргийг ерөнхийд нь аль болох бүрэн багтаагаад давтах ёс хэмээн нэрлэлээ. Энэхүү давтах ёсонд монгол хэлний үгийн үндэс давтахаас эхлээд, үг давтах, хэллэг давтах, өгүүлбэр давтах, эх давтах хүртэлх өргөн ухагдахууныг багтаан авч үзэхийг хичээсэн болно.

*Монгол Улсын Их Сургууль

1. R.L.Trask, 1993, “A Dictionary of Grammatical Terms in Linguistics”, Routledge
2. P.H.Matthews, 2005, “Concise Dictionary of Linguistics” OUP, pp.310

Монгол хэлний давталт, давтах ёсны талаар гадаад дотоодын эрдэмтэд дагнан болон дайвар шинжтэй судалсаар иржээ. Тухайлбал монголч эрдэмтэн Б.Ринчен, Т.А.Бертагаев, Г.Д.Санжеев, П.Бямбасан³, С.Нямсүрэн, У.Ж.Ш.Дондуков, Г.Ц.Пюрбеев, З.В.Шевернина, Т.Пагва, Т.А.Бертагаев, Ц.Сүхбаатар, М.Базаррагчаа, Д.Бадамдорж, Д.Алтангэрэл, Б.Пүрэв-Очир⁴, Ц.Өнөрбаян⁵ нар судалгаа хийж цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл тусгайлан бичиж янз бүрийн санал онол дэвшүүлж, эрдэм шинжилгээний бичгүүдэд хэвлүүлжээ.

Монгол хэлэнд хамгийн өргөн давтамжтай нь үг давталт бөгөөд энэ талаар эрдэмтэд голлон судалж иржээ. Монгол хэлний хувьд үг давталт нь маш түгээмэл үзэгдэл юм. Үг давтсанаар ямар ямар утга илэрхийлэх талаар эрдэмтэд дор бүрнээ тайлбарлаж, хэлзүйн болон үгийн сан утгын талаас нарийн судалгаа хийсэн байна.

Эрдэмтэн Т.Пагва, “Давталтын дүнд олон тоо, хүчлүүлэх утга, үйл үгийн байдлын утга голдуу илэрдэг.”⁶ гэжээ. Эрдэмтэн П.Бямбасан, “Үг давтахын нэгэн учир” бүтээлдээ, “Давтагдаж байгаа үйл үг хэлзүйн хэлбэрээрээ ижил ба ижил бус хоёр янз байдаг бол давтагдаж байгаа нэр үгийн хэлзүйн хэлбэр бас ижил ба өөр байхаас гадна үндсэн үгийн авианы бүтцийг хэвээр нь давтах, гутал мутал, дэвтэр мэвтэр, мах зах гэх мэтээр хоёр дахь үгийн авианы бүтцийг өөрчлөн давтах хоёр янз байна. Ижил давтагдаж байгаа нь нэр үгийн хоёр дахийг харьяалах, өгөх орших, гарах, заах, хамтрах, чиглэхийн тийн ялгалаар хувиргаж өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун зэрэг гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа холбогдох үгэнд нь захируулж болох ба хамаатуулах нөхцлөөр өөр үгтэй холбодог.”⁷ гэж давтамал үгийн үндсэн шинж чанарыг тодорхойлжээ.

Монгол хэлний давталтын бас нэг утга бол олны буюу олон тооны утга илэрхийлэл байна. Үүнийг олон эрдэмтэн нэгэн дугаар хүлээн зөвшөөрдөг. Энэ тухай Б.Пүрэв-Очир, “Нэр үгийн ерөнхий олон тооны утгыг илтгэх нэг задлаг арга бол давталт мөн... Энд хамааруулж буй нэг зүйл давталт бол бидний ойлгож байгаагаар үгийн язгуурт холбогдолгүй, харин үгийн хэлбэр давтсан давталт юм.” гэсэн бол Ц.Өнөрбаян, “Жинхэнэ нэрийг тодотгож байгаа тэмдэг нэрийг давталт тодотгуулагч жинхэнэ нэрийн ерөнхий олон тоог заана.” гэжээ.

Давтах ёсны хэлзүйн байгууллын талаар проф. Ц.Өнөрбаян нэлээд өргөн хүрээтэй судалгаа хийж орчин цагийн монгол хэлний давталтыг бүрэн давталт (full reduplication), бүрэн бус давталт (partial reduplication) гэж хоёр хувааж хэлзүйн бүрэн задлал хийсэн байна. Үүнд монгол хэлний жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, орон цагийн нэр, төлөөний үг, үйл үг, чимэх үгийг давтаж болно гэдгийг утга зохиолын жишээ баримтаар баталж, ялангуяа үйл үгийн давталтын хэлзүйн хэлбэрийн тогтолцоог гаргажээ. Ингэж тогтолцоог задлан нарийн судалсанаар давталтын утга илэрхийлэх үүрэг буюу голдуу олон тоо, давтамж, үйлийн болц, эрчим, ялгамж утга илэрхийлэх боломжийг тоочин гаргажээ.

Монгол хэлний давталтыг ажиглавал байгалиасаа давталттай болдог хөдөлгөөн, дуу, чимээ, зэрэг зүйлийг илэрхийлэхэд хэрэглэдэг нэг ёс байх шиг байна. Жишээлбэл, хүн амьтны дуу авиа, шувууны далавч гэх мэт араатан болоод гэрийн тэжээмэл амьтны явдал хөдөлгөөн, байгалийн элдэв үзэгдлийн давтамжит чимээ, үйл, зэрэг олон зүйлийг илэрхийлэхдээ тухайн үгийг хоёроос дээш давтах маягаар утгыг үзүүлдэг байна.

Бүрэн бус давталт буюу partial reduplication-ийн тухайд профессор Ц.Өнөрбаян бүрэн бус давталт гэдэгт “... бүрэн бус давталт нь үг бүтээх үүрэг нь давамгайлсан давталт юм. Монгол хэлний баримтыг ажиглавал бүрэн давталтаас бүрэн бус давталтыг дамжин зэрэгцсэн нийлмэл

3. П.Бямбасан, “Үг давтахын нэгэн учир”, 1978, [Хэлзохиол судлал, боть 13, 11-р дэвтэр, 87-97 дах тал]

4. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, утга, найруулгын үүрэг”, [Монгол хэлний өгүүлбэрзүй - 2, Уб., 89-110 дах тал]

5. Ц.Өнөрбаян, 2006, “Орчин цагийн монгол хэлний давталтын арга, түүний үүрэг”, [Монгол судлалын чуулган, Боть 6, Уб., 12-22 дах тал]

6. Т.Пагва, 1976, “Хэлшинжлэлийн удиртгал”, 119 дэх тал

7. П.Бямбасан, 1979 “Үг давтахын нэгэн учир” [Хэл зохиол судлал, 13-р боть, 9-р дэвтэр,] Уб., 87-97 дах тал.

үг үүсдэг зүй тогтолт дараалал байдаг. ... бүрэн бус давталт нь утгын хувьд задгай хэв шинжтэй байна...”⁸ гээд гөрөөс мөрөөс, эрээн мэрээн, арав марван, цаана маана, өнөөдөр мөнөөдөр, тийм мийм, усалж мусалж гэх мэт үгийг жишээ болгон авчээ. Давтмал үг түүх цуглуулах явцад бүрэн бус давталтыг ажиглавал монголын утга зохиолын хэл найруулгад цөөнгүй таарч байна. Жишээлбэл, “Сохор мохроо ч хайхралгүй соёо шүдээ ч хайрлалгүй үхээрийн муу чонотой л үзэлцэж гэнэ нэгийгээ.” (Ш.Гаадамба, “Сохор нохой”), “Жанжин манжин нь санд мэнд босон гүйлдэв.” Д.Нацагдорж, “Бүр харь элгийн хүнтэй үерхэж нөхөрлөх гээд байсан юм бол нутаг ус, дүр төрх нь арай эерүү юм орос моросуудтай нөхөрлөхгүй дээ.” (Ц.Буянзаяа, “Шинэ цагийн Молом тойны намтар”), “Үгүй байх аа, хавар эх нь очсон, үглэж дуулсан, цол мол хамгаалах юм ярьж байна гэсэн.” (Р.Ганбат, “Хадлангийн оросууд”); Ингээд бид монгол хэлэнд байдаг, монголын уран зохиолын жишээ баримтаар батлагдаж байгаа энэхүү бүрэн бус давталтыг “бүрэн хэмжээгээр” хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд яах аргагүй монгол хэлний давталтын тодорхой нэгэн хэв маяг мөн болно.

Монгол хэлний хувьд давталт бие даасан үзэгдэл мөн үү, биш үү гэдэг сонин юм. Давталтыг хамгийн их хольж хутгадаг үзэгдэл бол хоршоо үг юм. Энэ талаар зарим эрдэмтэд хорших үзэгдэл гэж үзнэ, зарим нь ялгаатай гэнэ, зарим нь бүр тэс өөр үзэгдэл гэж үздэг.

Монголч эрдэмтэн хэл судлаач Т.А.Бертагаев⁹, Г.Д.Санжеев¹⁰ нар хэлзүйн утга илтгэж байвал давтсан үг гэж хоршоо үгээс ялгаж байж. Профессор М.Базаррагчаа, “Үг хорших нь давтахыг, үг давтах нь хоршихын утгыг тус тус агуулсан байдаг тул үг давтахыг үг хоршихоос ялгахад төвөгтэй юм. Гэвч “эрээн мэрээн, үхэр мүйхэр, цав цагаан, хав хар, яв явсаар, гэр гэртээ гэх мэтээр язгуурыг бага сага өөрчлөн давтсан нь үгийн санжсан утгыг бус, үйлийн үргэлжлэх, давтах, эрчимжүүлэх, хэсэгчлэх зэрэг хэлзүйн хийсвэр утгыг илтгэж байна. Бага сага, ач тач, эрээн мяраан, хага хуга, хальт хулыт, арай чарай, шалдар булдар, илүү булуу, пүл пал, үүр цүүр, ахих дахих, эрвийх сэрвийх, урвах хөрвөх гэх зэрэг хоршоо үг нь давталтаар үүссэн юм шиг авч дээрх давталтаас чөлөөтэй бус, тогтвортой байдгаараа ялгаатай юм. Тодруулбал, эрээн мяраан, хага хуга гэх мэтээр авианы сэлгэц болон гийгүүлэгчийн сугарлаар нэг үгээс салаалан үүссэн тул адилагтар үгс давтагдсан боловч “Яван явсаар хүн хүн гэр гэртээ орцгоожээ.” гэхчилэнгийн чөлөөт давталтыг бодвол хоршиж буй үг нь хэвшин тогтворжсон байдаг. Үүнээс үзвэл давтах шинж нь хэлзүйн утгыг илтгэх бол хорших шинж нь үгийн сангийн утгыг илтгэж байна.”¹¹ гэжээ. Өөрөөр хэлбэл хорших, давтах хоёр бол хоёр өөр утга илэрхийлдэг хоёр өөр зүйл гэсэн санаа гэж эндээс ойлгож болно.

Профессор Б.Пүрэв-Очир, “давталт бол өвөрмөц системтэй ба хорших-оос бас ч ялгаатай, судлах эзнээ хүлээж байгаа монгол хэлшинжлэлийн нэг сонин сэдэв, олон талтай асуудал мөн... давталт бол хоршоо үг, хоршоо зэрэгцлээс утга, үүрэг, хэв шинжээрээ ялгаатай хэл, хэлэхүйн учир холбогдолтой өөр үзэгдэл мөн.”¹² гэж 1998 онд бичиж байж.

Судлаач Ч.Баттулга, “... давтан хоршсон нийлмэл үгийг нэгэн төрлийн өвөрмөц давталт хэмээн үзсэн эрдэмтэдтэй санал нийлж байна.”¹³ гэсэн боловч дүгнэлтдээ, “монгол хэлний цуурай үг буюу давтан хоршсон нийлмэл үг нь монгол хэлний нэн эртний үзэгдэл бөгөөд хоршоо үгээс үүсэл гарал, бүтэх аргын хувьд ялгаатай, авиалбарзүй, бүтээвэрзүйн шинжтэй дэлхийн олон хэлэнд байдаг нэг төрлийн давталт юм.”¹⁴ хэмээн бичжээ.

8. Ц.Өнөрбаян, 2006, “Орчин цагийн монгол хэлний давталтын арга, түүний үүрэг” 12-22 дах тал, [Монгол судлалын чуулган, №6, (36)]

9. Т.А.Бертагаев, 1971, “Сочетания слов и современная терминология”, М, 1-33 дах тал

10. Г.Д.Санжеев, 1941, “Грамматика бурят-монгольского языка, М-Л., 116-123 дах тал

11. М.Базаррагчаа, 1990, “Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд”, Уб., 5-6 дах тал

12. Б.Пүрэв-Очир, мөн өгүүлэл, 90 дэх тал

13. Ч.Баттулга, 2012, “Монгол хэлний хоршоо үгийг үүсэл гарлын асуудал”, [Монгол судлалын чуулган, №12(47)] 71 дэх тал

14. Ч.Баттулга, мөн үгүүлэл-ийн 74 дэх тал

Мөн тус өгүүлэлд Ч.Баттулга, монгол хэлний давтсан үг буюу цуурай үгийг “1-рт хоёр үг нь хоёулаа утгатай, 2-рт эхний үг нь утгатай, 3-рт хоёр үг нь хоёулаа утгагүй, нийлж нэг утга илэрхийлдэг” хэмээн ангилах санал дэвшүүлсэн байна.

Монголч эрдэмтэн А.А.Дарбеева “давталт бол хоршоо үг биш, давталт хоршоо үг хоёр нь бүтэц, үгийн сан, хэлзүйн утгаараа ялгаатай гэж үздэг.” гэж бичжээ.

Бид үүний өмнөхөн хэвлүүлсэн монгол хэлний хоршоо үгийн анхны толь бичигтээ¹⁵ давтмал үгийг хоршоо үгээс тусад нь авч үзэн толилсон бөгөөд тэр туршлагадаа тулгуурлан энэхүү бичил санг бүрдүүлэн хэвлүүлж байгаа юм. Бидний ажигласнаар үгийн утгаас нь авч үзсэн ч хоршиц буюу хорших ёс бол хэлбэр бүтцийн хувьд хоёр өөр утгын хувьд нэн ойр буюу эсрэг элементийн хүрээнд буюу А эсвэл В гийн хооронд буюу [A and B] бүтэцтэй баймаар харин давталт буюу давтах ёс бол хэлбэр бүтцийн хувьд хоёр ижил буюу бараг ижил элемент буюу А ба А, эсвэл В ба В-гийн хооронд буюу [A and A or B and B] бүтэцтэй байж болох учраас хорших, давтах хоёр бол шал өмнөө хоёр өөр асуудал байна гэж үзэж байна.

Тийм учраас хоршиц бол давтац биш, давтац бол хоршиц биш юм. Ингээд энэхүү толь бичигт давталт мөн гэж баталж оруулсан хэлний жишээ баримтаас үзвэл давталт бол хоршоо үгээс тэс өөр ялгаатай хэлний бие даасан үзэгдэл мөн гэж тодорхойлох саналтай байна.

Яагаад хоршоо биш гэж үзэхийн хувьд дээр дурдсан эрдэмтдийн санаа онооноос гадна бусад судалгааг сөхөн үзвэл тэртээ 1951 онд Ш.Лувсанвандан, Б.Дэмчигдорж нарын “Монгол хэлний зүй” номын нэгдүгээр дэвтэрт, “...хоёр өөр үндэс бүхий үгсийг хоршиж шинэ үгийг бүтээдэг. Жишээлбэл, халуун хүйтэн, цаг уур, худаг ус гэхэд уул үгсийг дан дангаараа байснаас өөр шинэ үгсийг бүтээсэн гэж үздэг. Ингээж бүтсэн үгийг хоршоо үг гэнэ.” гэсэн нэг тодорхойлолт байдаг бөгөөд энэ бол хоршоо үгийн жинхэнэ мөн чанарыг илэрхийлсэн тодорхойлолт гэж үзэж байна. Гэвч тэр номдоо “бага сага, эрээм мэрээн, дарга марга-ийг давтан дуудсан, цав цагаан, хав хар зэргийг мөхсөн язгуурт в тулгаж, давтан дуудсан, хүн хүн, газар газар гэхчлэн нэг үг давтсан, яван яван, яв явсаар гэхчлэн үйл үгийг давтсан хоршоо үг бүтэж байна.” хэмээн оруулжээ. Иймэрхүү маягаар хольж хутгасан зүйл бол их байна.

Давталт бол үгийн сангийн биш хэлзүйн үзэгдэл гэж үзэж болох бөгөөд учир нь шинэ үг бүтээж байгаа биш шинэ утга үүсгэж байгаа гэдгээрээ онцлог юм. Монгол хэлний давталтаар хэлзүйн өөр өөр утга үүсэж байдаг нь утга зохиолын жишээ баримтаас үзвэл илэрхий байна. Б.Пүрэв-Очир “Хуучин сүмийн дээвэр доор шувуу шувуундаа жиргэн, хошуу хошуугаа нийлүүлэн шувуу шувуундаа дуулна. (Б.Лхагвасүрэн) гэдэг өгүүлбэрт шувуу шувуундаа, хошуу хошуугаа, гэсэн давталт давтагдаж байна. Энэ жишээг ажиглавал хоёр дах үгийн бүтцэд өгөх оршихын болон ерөнхийлөн хамаатуулахын нөхцөл нэмж залгаснаас болоод англи хэлний bird to bird гэсэн шиг утга үүсэх бөгөөд нэг шувуу нөгөө нэг шувуунд гэсэн өөр утга үүсэж байна. Гэтэл шувуу шувууны гэвэл энэ нь every single birds гэсэн шиг утгат үүсгэж байх шиг. Иймэрхүү давталт нь аливаа гадаад хэлэнд орчуулахад илүү анзаарагдаж утга нь ялгарч мэдэгдэж байдаг бөгөөд гадаад хэлний орчуулгыг давтмал үгийн утгыг ялгаруулах бас нэгэн шалгуур болгож болох талтай.

Гэтэл давталтаас ижил үг хэллэг үүсэх тохиолдол бий бөгөөд үүнийг ялгаж салгаж үзэх учиртай. Тухайлбал, дээрх шувуу шувуундаа гэдэг давтсан хэлбэр нь хоёр өөр утгыг үзүүлэх бөгөөд энэ нь гагц өгүүлбэрийн болон найруулгын хам сэдвээс шалтгаалах юм. Жишээ нь, “Шувуу шувуундаа бүр том тас шувуу шүү” гэдэг үгүүлбэр байя гэж үзэхэд энд байгаа шувуу шувуундаа бол утгыг лавшруулсан, ялгасан утга илтгэх бөгөөд шувуу шувууны дундаас, шувуу шувууны дотроос гэсэн шиг утга илэрхийлэх юм.

Профессор Б.Пүрэв-Очир, “монгол хэлэн дэх давталтын онцлог, хэв шинж, утга, үүргийг ажиглахад авианзүйн учир холбогдлоос үгзүйн учир холбогдолтой болж, улмаар үгийн сан-

15. Ж.Бат-Ирээдүй, 2011, “Монгол хэлний хоршоо, давтмал үг хэллэгийн сан”, Уб.,

өгүүлбэрзүйн учир холбогдолтой болох тийм хандлага, тогтолцоо байна.”¹⁶ гэж үзжээ. Бид монгол хэлний давталтыг бүрэн ба бүрэн бус давталт хэмээн ангилах профессор Ц.Өнөрбаяны саналтай бүрэн санаа нийлж байгаа бөгөөд харин бүрэн бус давталтад хамруулсан нэгэн зүйл давталттай санал нийлэхгүй байгааг энд дэлгэрэнгүй тайлбарлана.

Мөн давталтын ерөнхий шинжийг ажиглаж давталтын илэрхийлж байгаа утгын талаар тодорхой тогтолцоо бүхий зарим ажиглалт хийснээ толилуулж байна. Монгол хэлний давтамал үгийн хувьд “давтсан үг нь заавал язгуур юм уу үндэс нэгтэй байх учиртай. Хэлзүйн учир шалтгаанаар төрөл бүрийн дагавар нөхцөл залгаж болох боловч заавал үндсэн үгийг давтсан байх учиртай.

Тийм учраас монгол хэлний “там тум, эл хуль, дэл сул, мурий сарий, бүдэг бадаг, пид пад, хар хур, хам хум, жирэв зурав, ярвиг яршиг, ум хум, гэх мэт эхний үгэнд оролцсон гийгүүлэгч юм уу эгшиг дангаараа юмуу давхраараа өөрчлөгдөж байгааг нь хоршоо үгэнд, харин үндсэн үгийн эхний үсэг дээр нэмэгдэх юм уу тухайн үгийг бүтцийн хувьд өөрчлөхгүйгээр бүтэн болон хагас давтаж байгаа үгсийг давтамал үгэнд багтаах саналтай байна. Тухайлбал, “ов тов, ач тач, ой той, бүүр түүр, мөлгөр гөлгөр, тахир махир, сарий мурий, үүр цүүр, гангар гунгар, бага сага, нал шал, чим чим, чив чив, хон хон, тог тог, бувар бувар, бөн бөн, бөндөг бөндөг, хонь монь, морь зорь, ном зом, идэх мэдэх, харах марах, үймэн сүймэн, илбэ жилбэ,” гэх үгс нь давтамал үг болно гэж үзэж буй юм.

Харин профессор Ц.Өнөрбаян нарын бүрэн бус давталтын 2.2-т хамруулан үзсэн “өнгө, хэлбэр хэмжээ, дүр төрх заасан тэмдэг нэрийн утга эрчимжүүлэх арга”¹⁷ хэмээн нэрлэсэн тэмдэг үгийн эхний үе дээр “в” гийгүүлэгч нэмж “давтах”-ыг бид давталт биш гэж үзэж байна. Энэ бол хэдийгээр тухайн үгийн язгуурыг хадгалж байгаа боловч утгыг эрчимжүүлж, хүчжүүлж, нэмэлт хүч өгч буйгаас өөр юу ч биш юм. Тийм учраас энэхүү бөв бөөрөнхий, нов ногоон, бов бор, був буурал, хүв хүрэн, шив шинэ, хав хар, дув дугуй, хув хуурай, цав цагаан, дув дуугай, цэв цэнхэр гэх мэтээр үүсэж болох тэргүүтнийг бид давталт биш гэж үзлээ.

Ийм учраас энэхүү давтсан үгийн толь бичигт ч иймэрхүү жишээ оруулсангүй. Үүнийг бас проф. Б.Пүрэв-Очир “Монгол хэлэнд цав цагаан, цэв цэнхэр, хөв хөх, ув улаан, нов ногоон, ив ижил, ав адил, зав залуу гм-ээр гол төлөв тэмдэг үгийн язгуурыг эс өөрчлөн давтаж тухайн тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлдэг ёс арвин бий. Энд ца, цэ, хө, но, за гм язгуурыг өөрчлөн давтаагүй зөвхөн язгуурын авианы бүрхүүлд –в авиа жийрэглэж, авиан зүйн аргаар давтсан онцлогтой. Ийм хэв маягийн давталт нь мөн л микро давталтын нэгэн хэв маяг бөгөөд хүчлүүлэх утгын холбогдолтой гэж үзэж болох юм.”¹⁸ гэсэн дээрх өгүүлбэрт давтаж, өөрчлөн давтаагүй, давтсан хэмээн бичсэн нь нэг бол давталт гээд байгаа юм шиг, эс бол үгүй юм шиг зөрчилтэй санаатай болсон байна. Монгол судлаач З.В.Шевернина, “Давтагдаж байгаа үйл үг хэлзүйн хэлбэрээрээ ижил ба ижил бус хоёр янз байдаг”¹⁹ гэж үзсэн нь бидний бодоход давталт гэдэг үгийнхээ утгад нэгэнт таарахгүй бөгөөд давталтын гол шинж бол хоёр гишүүн хоёул адил байх ёстой гэдэг ойлголтондоо таарахгүй байна. Эрдэмтэн П.Бямбасан бээр, “Бид нэг үгийг давтан хэрэглэхийг хэлзүйн утга илрүүлэх арга, давтагдаж байгаа нэг үгийг энх тайван, эрдэм мэдлэг, суртал нэвтрүүлэг, ах дүү, халуун хүйтэн гэх мэт хоршсон нийлмэл үгтэй адил зүйл биш, товчхон хэлбэл хоршсон нийлмэл үг биш гэж бодож байна.” хэмээн үзжээ.

Харин тэрбээр, “Монгол хэлэнд нэр үг, үйл үг, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, аялга үг зэрэг олон аймгийн үгсийг давтан хэрэглэнэ. Судалгаа шинжилгээний зүйл, хэлний

16. Ч.Баттулга, мөн өгүүлэл, 99 дэх тал

17. Ц.Өнөрбаян, мөн дээрх өгүүлэл, 19 дэх тал

18. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, утга, найруулгын үүрэг”, [Монгол хэлний өгүүлбэрзүй, Уб.,] 91 дэх тал

19. Шевернина З.В 1974, “Редупликации деепричастий в монгольском языке [Исследования по восточной филологии. М] 333-338 дах тал.

материалаас үзвэл давталт нь хоёр гишүүнтэй байх бөгөөд тэр хоёр гишүүн нь яг адил нэг хэлбэрээр давтагдах, хоёр гишүүний нь аль нэг нэр, үйлийн ямар нэгэн нөхцөл авч хэлзүйн хувирлаар хувиран давтагдах, нэгний нь эхний авиаг м, з зэрэг авиагаар сольж давтах, давтах үг нь эгшгээр эхэлсэн бол м, з зэрэг гийгүүлэгч нэмж давтах хэдэн янзын хэлбэртэй байна.”²⁰ хэмээн тодорхойлсон байна. Ингээд цааш нь, “Нэр томьёоны ихэнхи хувийг эзэлж байгаа нийлмэл нэрлэлтэд хоёр өөр үг хоршуулан бүтээсэн хоршоо нийлмэл үг олон байгаа боловч нэг үгийг хүн хүн, айл айл гэх мэт ижил буюу малгай залгай, шавар мавар гэх мэт нэгийн нь авианы бүтцийг хувирган давтаж бүтээсэн нэр томьёо нэг ч байхгүйгээр барахгүй мал мал, хүн хүн, айл айл, дээл мээл, мах зах, бодол модол, ааш мааш гэх мэт үгээр нэрлэгдсэн ямар ч юм үзэгдэл үнэн хэрэгтэй хаана ч байхгүй учраас монгол хэлний ямар ч толь бичигт давтан бүтсэн нэр үг, үйл үг ч байдаггүй билээ. Энэ нь үгийн сангийн хоёр өөр нэгж болох хоёр өөр үгийг нийлүүлбэл гуравдагч өөр үг бүтэхээс биш, үгийн сангийн нэг нэгж болох нэг үгийг яаж ч давтахад өөр үг болдоггүйг гэрчилж байна. Энэ бол усан дээр ус нэмбэл арвижихаас биш, тос болдоггүйтэй адил орчлонгийн жам диалектикийн хууль билээ.”²¹ гээд “Монгол хэлэнд үг давтаж үг бүтэх ёс байхгүйн дагуу давтан хоршсон нийлмэл үйл үг монгол хэлэнд байхгүй. Нөхцөл үйлийг хэд хэдэн янзаар давтаж байгаа нь үйл үг бүтээж байгаа бус үйлийн болц байдлыг илрүүлэн байгаа арга хэрэглүүр болж байна.” хэмээн үзжээ.

Ингэж үзвэл давталт нь хэлний зүйн асуудал болж түүний арга хэлбэрээр утгыг үзүүлдэг үзэгдэл болох нь тодорхой байна. Бидний хувьд цуглуулсан хэлний хэрэглэгдэхүүнийг ажиглан үзвэл монгол хэлний давтамал үгийг бүтцийн хувьд дараах мэт байж болох юм хэмээн үзэж байна.

Үүнд: үг + үг (ангас ангас, байн байн, *барь барь, бичиг бичиг, биш биш, дассаар дассаар, дош дош, дуудаад дуудаад, ерөөл ерөөлийн, ёдор ёдор, жигүүртэн жигүүртэн, имрэн имрэн, манан манан манан, майл майлсаар, наадан наадан, очиж очиж, гэх мэт*), холбоо үг + холбоо үг (амаа ангайгаад, амаа ангайгаад; даргиатай болоод, даргиатай болоод, дуниарч тодроод л, дуниарч тодроод л, жаргалан будан, жаргалан будан, жижигхэн түүний, жижигхэн түүний, жижигхэн цагаан, жижигхэн цагаан, цахилан цогин, цахилан цогин гэх мэт), хэллэг + хэллэг (бага л харын, бага л харын, журай гэлдэн журай гэлдэн; зуун намар, зуун намар; манай цэцэрлэг манай цэцэрлэг; нарийн жанхай, нарийн жанхай; намрын шувуу, намрын шувуу; нэг үе нэг үе; нэгэн цагт, нэгэн цагт; нэг л мэдэхэд, нэг л мэдэхэд; шүлэг минь хүлэг минь, шүлэг минь хүлэг минь гэх мэт), өгүүлбэр + өгүүлбэр (амархан ч юм даа, амархан ч юм даа; бөжинхөн чиг туулай би, бөжинхөн чиг туулай би; гутал гэмээ нь гутал юм, гутал гэмээ нь гутал юм; дөрөөн дээрээ дарсан тамгатай, дөрөөн дээрээ дарсан тамга нь; зүгээр сууна, зүгээр сууна; лойж байна, лойж байна; наадаж сууна, наадаж сууна, цас орлоо, цас орлоо; өнгийх л юм өтөг, өнгийх л юм өтөг; гэх мэт) давтах гэж ерөнхийлөн хувааж үзэж болох юм.

Харин үгийн бүтцийн хэмжээнд бүр нарийвчилан авч үзвэл дотроо нэр үг + нэр үг (аяс аяс, бөөр бөөр, бурхан бурхан, горхи горхины, гөөлөө, гөөлөө, гөөлөө, гүрэн гүрэн, гэр гэр, дуу дууны, жил жил, зан зан, зун зуны, зүг зүг, лүг лүг, могой могой, мод мод, морь морио, найр найр, ноёд ноёдын, ном ном, нүгэл нүглийг, гэх мэт), үйл үг + үйл үг (асуумаар асуумаар, багассаар багассаар, байдаг байдаг, байн байн, босон босон, бөртөлзөх бөртөлзөх, бутраах бутраах, бүлхийх бүлхийх, ганганан ганганан, гүйлээ гүйлээ, гээн гээн, дуулж дуулж, дүүлэн дүүлэн, жирэн жирэн, жууман жууман, зажилж зажилж, зайлан зайлан, зөрөн зөрөн, зугтах зугтах, майлсаар майлсаар, мөрөөдөн мөрөөдөн, мяралзан мяралзан, наадан наадан, найган найган, нахилзан нахилзан, ноцон ноцон, гэх мэт.), холбоос үг + холбоос үг (агаад агаад, *гэж гэж, гэмээ гэмээ, болоод болоод, гэх мэт*), тооны үг + тооны үг (арав арав, бум буман, түм

20. П.Бямбасан, 1978, “Үг давтахын нэгэн учир”, [Монгол хэлний онол, бүтцийн асуудалд, 2006, Уб.,] 343-344 дэх тал.

21. Мөн өгүүлэл, номын 347 дах тал

түмэн, гучин гучин, далан далан, дөрөв дөрөв, жаран жаран, зуу зуун, мянга мянга, наян наян, гэх мэт.), тэмдэг үг + тэмдэг үг (ариун ариун, аяар аяар, бай бай, балга балга, бор бор, бөн бөн, бөмбөр бөмбөр, бөөн бөөн, бувар бувар, бушуу бушуу, бүгээн бүгээн, гүдгэр гүдгэр, гялс гялс, давхар давхар, дан дан, дугуй дугуй, дүүрэн дүүрэн, дэндүү дэндүү, ёдор ёдор, жижиг жижиг, жин жин, зөөлөн зөөлөн, мөнгөн мөнгөн, муруй муруй, мэлмэс мэлмэс, найгас найгас, намс намс, гэх мэт.) төлөөний үг + төлөөний үг (дараа дараагаар, хэн хэндээ, үүгээр түүгээр, дэргэдэх дэргэдэх, ингэх ингэх, ингэсээр ингэсээр, минийх минийх, тийм тийм, тэгэн тэгэн, тэр тэр, гэх мэт), чимэх үг + чимэх үг (биш биш, бөвөг бөвөг, бөг бөг, вааг вааг, ваар ваар, год год, годос годос, жин жин, ичиг ичиг, нэн нэн, гэх мэт) гэсэн хэлзүйн ижил хэлбэрүүдийг давтсан бүтэцтэй давталт үүсэж байдаг байна.

Монгол хэлний жишээ баримт, найруулгын ур маягыг нягтлан үзвээс давтмал үгийн илэрхийлж байгаа хэлзүйн утгыг доорх мэт ангилж болмоор санагдана. Тухайлбал,

Үйл хөдлөл зөвхөн давтах буюу дахин давтан болохыг заах утга илэрхийлэх: ангас ангас, тонгос тонгос, нуг нуг, атис атис гэх мэт.

Үйлийг эрчимжүүлэх утга илэрхийлэх: өрдөн өрдөн, чагнан чагнан, мяралзан мяралзан, дүүрэнхэн дүүрэнхэн, гэх мэт.

Хүн ба юм, үзэгдлийн олны буюу төрлийн олон тооны утга илэрхийлэх: айл айл, хүн хүн, мал мал, гэх мэт. Үүнийг П.Бямбасан, “Нэр үгийг ижил ба ижил бус хэлбэрээр давтаж, давтагдан байгаа нэр үгээр нэрлэгдсэн зүйл ганц бус болохыг үзүүлдэг байна.”, проф. Б.Пүрэв-Очир “... үгийн хэлбэр давтсан, үгзүйн үндэстэй, хэлзүйн арга болдог давталт” хэмээн нэрлэжээ.

Үгүйсгэх хэлц утга илэрхийлэх: явж явж, очиж очиж, байж байж, тэгж тэгж, гэх мэт.

Ялгах буюу утга илэрхийлэх: шувуу шувуундаа, хүн хүндээ, нохой нохойдоо гэх мэт.

Дахин давтан болох дүр байдлын утга илэрхийлэх: бувар бувар, бөг бөг, тас тас, гэх мэт.

Давуу зэрэг илэрхийлэх: сайхнаас сайхан, ариухнаас ариухан, эмзэгээс эмзэг, гэх мэт.

Дуу чимээ илэрхийлэх: тас тас, шал шал, шол шол, шүг шүг, дүнгэр дүнгэр, хон хон, хав хав, хогир хогир, гэх мэт.

Цаг хугацааны утга буюу үйл хөдлөл зэрэг нь харьцангуй удаан хугацаанд үргэлжлэн болсон утга илэрхийлэх: явж явж, алхаж алхаж, гүйж гүйж,

Монгол хэлний давтмал үгийн бас нэг онцлог бол ижил хэлбэртэй, өөр утгатай байж болдог бөгөөд бичвэрийн хам сэдвээс хамаарч утгыг ойлгох шаардлагатай болдог байна. Өөрөөр хэлбэл давтмал үгийн ижил үг гэж бий гэсэн үг. Тухайлбал, явж явж гэдэг давтмал үгийн утгыг авч үзвэл “Балбар хонин дотроо явж явж нэг тарган халзан ирэг барьж аваад хүчийг нь үзсэнээ тавьчихав.” (С.Дашдооров) гэсэн эхний өгүүлбэрт хонин дотроо их л удаан явсан гэсэн цагийн утга илэрхийлж байгаа бол “Агваан явж явж харин овоо юм мэддэг нэгэнтэй ярьчихсан биш биз.” (С.Пүрэв, “Сүүдэр догширох цаг”) гэсэн дараагийн өгүүлбэрт адаг сүүлд нь, эцсийн дүнд гэсэн шал өөр бүр үгүйсгэх утга илэрхийлж байгааг ажиглаж болно.

Давталтын тухай ярихад түүний найруулгын онцлог бусад хэв маяг, хэлбэр шинжүүдийг заавал авч үзмээр санагдана. Монгол яруу найраг, уран зохиолын төрөл бүрийн хэлбэрт хэлзүй, найруулга зүйн үүрэг учир шалтгаанаар хэлний төрөл бүрийн давталт үүсэн бий болсоор байна. Энэхүү найруулгын давталтын ур маягууд бол сэтгэлгээний царааг илэрхийлэх, уран зохиолын боломжийг харуулах бас нэгэн сонин баримт яах аргагүй мөн гэж бодогдоно. Энэхүү найруулгын үүргээр үүсэн бий болж байгаа давталт бол хэлзүйн давталтаас бүтэц, үүргээрээ нэлээд өөр бөгөөд гагцхүү зохиолыг уран яруу болгох, хүмүүний ой тойнд ойлгуулах, утга яруу цогцолыг олох, сондгойруулахгүй байх зэрэг олон зүйлд учир холбогдолтой давталтын хэв маяг болж байна.

Монгол хэлний утга зохиолын найруулга тэр дундаа яруу найрагт мөр алгассан давталт арвин буй. Үүнийг Ц.Сүхбаатар “жаазалсан давталт”²², Б.Пүрэв-Очир “мөр өргөсөн аяс хэв маягийн

22. Ц.Сүхбаатар, 1988 “Орчин цагийн монгол хэлний найруулга зүй”, Уб., 146 дах тал

найруулга зүйн учир холбогдолтой давталт”²³ гээд өгүүлбэрийн бүтэц хэв маяг, өгүүлэх зорилго, утгын талаас ажиглаж тайлбарласан зүйл байна. Бидний утга зохиолын баримтаас олсон жишээ хэмээвээс, “Сүүмэлзэнхэн харагдах нь сүмтэй будрын чулуу, сүүмэлзэнхэн харагдах нь миний нэг алдрай юу.” (Ар хөвчийн унага МАУДуу), “Дүн шөнөөр гэв гэнэт хуучин бишгүүрийн дуу хангинаж цочсон шувууд чиг зүггүй шидсэн чулуу шиг бараа тасарлаа, дүн шөнөөр.” (Б.Ичинхорлоо), “Мартсан би, чамайг мартсан магад үнэний анхны харц.” (Б.Ичинхорлоо), “Өвсний шуугианд шивнэхийг сонсоод нэг л мэдэхэд сэтгэл мэлмэрнэм, нэг л мэдэхэд үс онгоном.” (Б.Ичинхорлоо), “Би чамдаа очно, нулимс ивлэх талын хөх тэнгэ болж очно, нуугдаж үүлэн цаанаа туньсан наран болж мандана, үнэнийг худалд багтаасан сураг болж алдарна, чамдаа би очно.” (Б.Ичинхорлоо, “Аяз”)

Ер нь монгол хэлний утга зохиолын төрөл бүрийг баримтыг сайн ажиглавал монгол хэлэнд хэлзүйн хэлбэрийн давталт, уран зохиолын буюу найруулгын давталт гэж хоёр зүйл давталт байх шиг. Хэлбэрийн давталт нь гадна үндсэн хэлбэрээрээ адил бөгөөд харин утгын давталт нь үндсэн хэлбэрээрээ адилгүй өөр өөр байж болох ч гагцхүү утгын хувьд энэ тэнцүү буюу давтагдаж байх бололцоотой гэж үзэж байна.

Энэ тухай эрдэмтэн Э.Пүрэвжав, “Өгүүлэгч этгээд хэлж байгаа зарим үгийнхээ утга санааг лавшруулах, сонсогч, уншигчийн анхаарлыг татах, өгүүлж байгаа зүйлдээ хандлах хандлага, сэтгэлийн хөдөлгөөн зэргийг илрүүлэх үүрэгтэй давталт байхаас гадна, найруулгын өнгө аястай арга барилд хамаарах давталт ч байдаг.”²⁴ хэмээн тэмдэглэжээ.

Монголын уран зохиолын найруулгуудыг нягтлан анзаарвал монгол хэл сэтгэлгээний онцлогийг илэрхийлсэн төрөл бүрийн давталт байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, үг алгасан давтах давталт гэж нэрлэж болмоор нэгэн зүйл давталт байна. Жишээ нь: “Саальчин хонгор бүсгүй минь саагаарай, малаа саагаарай, ... Саальчин хонгор бүсгүй минь самраарай, сүүгээ самраарай, саальчин хонгор бүсгүй минь савлаарай сүүгээ савлаарай.” (Ц.Цэдэнжав, “Сүүний тухай дуу”)

Мөн ахиулал маягийн давталт гэж нэрлэж болмоор бас нэг сонин давталт байгаа бөгөөд энэ нь шүлэг яруу найргийн мөрөөс мөрт, шадаас шадад ахиулах хүч оруулах маягаар давтдаг давталт байна. Жишээ нь: “Шүлэг минь хүлэг минь чи бид хоёр шүүдэр мэлтрэн цэцэг уйлтал дуулах ёстой, шүлэг минь хүлэг минь сар мэлмэрэн хээр хонотол дуулах ёстой.” (Б.Явуухулан, “Шүлэг минь хүлэг минь”), “Униар татсан хөндийд чинь унаган бие минь өсөн жаргав аа, унаган бие минь жаргасны учраа ухаан хүчээ тандаа зориулна.”, “Рашаан болор мөрөнд чинь алдхан бие минь торнин жаргав аа, алдхан бие минь жаргасны учраа амь насаа тандаа зориулна.” (Ж.Шагдар, “Эх орон танаа”), гэх буюу “Уулсын эгшиг татах цуурианаас унаган насны дуугаа сонслоо, унаган насны дуугаа сонсохлоор ухаан санаа уужранхан байна, урсгал түргэн голын боргионоос уяхан зүрхний цохилтоо чагналаа, уяхан зүрхний цохилтоо чагнахлаар урам сэргээд жавхаажин байна.” (Д.Цэдэв, “Буянт нутаг”);

Голдуу шүлэг яруу найргийн нэг мөр, нэг өгүүлбэрийн эхлэл болон дунд, мөн төгсгөлд үгийг ахин ахин давтах давталт байна. Жишээлбэл “Тэмээ – таван хошуу малын минь нэг, тэмээ – таван амьд эрдэнийн минь нэг, тэмээ – таван тивийн улсаас манайд олон нь бий, тэмээ - тал, хангай, говь гурван нутагт минь дүүрэн бий.” (П.Бадарч, “Тэмээ”), “Голын доторхи хуурайг хэн мэдэрнэ, галын доторхи жаварт хэн жихүүцнэ, амтганы доторхи гашуунд хэн ярвайна, аниргүйн доторхи хөгжмийг хэн сонсоно.” (З.Түмэнжаргал), “Чимээ аниргүй шөнө, чимээ аниргүй газарт, чимээ аниргүй сарыг угтаж, чимээ аниргүй салцгаав.” (До.Цэнджав, “Чимээ аниргүй шөнө”) гэх мөрүүдэд тэмээ, таван, нэг, доторхи, хэн, чимээ аниргүй гэх үгсийг мөр бүхний эхэн, дунд, адагт давтаж тухайн үйлийн болц байдлыг тодруулах зорилгоор хэрэглэжээ.

23. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, тэдгээрийн бүтэц, хэвшинж, утга, үүрэг” , [Монгол хэлний өгүүлбэрзүй] Уб., 104-108 дах тал

24. Э.Пүрэвжав, “Пагмын Бямбасан”, 2004, [Монгол хэл бичгийн судлал, Уб.,] 15 дах тал

Үүнийг утга зохиол судлаачид бол дунд холболт (middle rhyme) гэж үздэг юм байна. Тухайлбал, д-р Г.Галбаяр, "... зүйр цэцэн үгнээс харахад шадуудын толгой сүүлийг нарийн чанд холбосноос гадна дунд холбоц тэднээс дутахааргүй зарим талаар бүр гүн холбогдсон байна. Энэ жишээнд ихэвчлэн ижил үгээр (давталт ЖБ) дунд холбоцыг хийсэн онцлог харагдаж байна. ... нэг үгийг давтаж юм уу хоршоо холбоо үгээр дунд холбоц хийхээс гадна ойролцоо, эсрэг утгатай үгээр дунд холбоц хийх нь түгээмэл үзэгдэл байна."²⁵ гэжээ. Гэхдээ дээрх дундын холбоц гагц яруу найрагт биш мөн үргэлжилсэн үгийн зохиолд байж байдаг. Жишээ нь: "Учир нь Сарнай ч ялгаагүй, Болор ч ялгаагүй гэртээ харьсан хойноо бие биеэ санана." (Д.Гармаа, "Үнсэлт")

Зөвхөн өгүүлбэрийн төгсгөлд давтах ёс гэж бас байна. Жишээлбэл, "Монголын үзэсгэлэнт саран гуа намайг төрүүлсэн ижий, яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ижий, зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ижий, зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ижий." (Д.Нацагдорж, "Миний ижий"), "Эх бүхний цээжнээс эхэлдэг элбэг урсгалтай сүүн мөрөн ижий мөрөн, үрээ л дагаж урссан үйлийн үртэй цагаан мөрөн ижий мөрөн, ижий ижий адилхан ижий мөрөн, миний л ижий адилхан ижий мөрөн." (Б.Лхагвасүрэн), "Эцэг өвгөдийн сүнс биднээс асууж байна, эрхт төрийн сүлдэн биднээс асууж байна." (Ж.Мөнхбат, "Бурхан хүсэл"), "Цахирмаа жижиг цэцэг царс мод том цэцэг, далимандарваа жижиг цэцэг, далдуу мод том цэцэг." (З.Түмэнжаргал, "Цэцэгний тухай", "Танцаардан суухад цэцэг ч хүйтэн болоод уйтай, ганц нэгээр шившрэх бороо ч хүйтэн болоод уйтай, тэнгэрийн доорхи нангиад тосгон ч хүйтэн болоод уйтай, тэвэрье гэвч чи холын хол, сэтгэл хүйтэн болоод уйтай." (До.Цэнджав, "Хүйтэн болоод уйтай"), "Тайван бор нүд чинь талимаарахаараа хөөрхөн, гэрэл татсан гээг чинь намирахаараа хөөрхөн, хацрын чинь хонхорхой мишээхээрээ хөөрхөн, зөөлөн ягаан уруул тань жимийхээрээ хөөрхөн." (Ц.Цолмон, "Дандаа"), "Соёрхож чамд бурхан мутраа тэнийлгэсэнд хотлоор гайхах хагас, бишрэх хагас, цогт зүрх юүгээн чи нүглийн хальс болгосонд тэд харин харамсах хагас, жигших хагас, сормосноосоо үе үе бороо дуслуулан явдгийг чинь сонсоод би бээр өрөвдөх хагас, шаналах хагас." (З.Түмэнжаргал, "Тас зөрөхдөө ч би өөрийнхөөрөө, тачаах үзэн ядахдаа ч би өөрийнхөөрөө, тарчилж зовоходоо ч би өөрийнхөөрөө, танхайрч туйлахдаа ч би өөрийнхөөрөө." (Б.Лхагвасүрэн, "Өөрийнхөөрөө"), "Бөөцийлөх бүр цаашаа, бөмбөрөх бүр цаашаа, аргадах бүр цаашаа, алганд өнгөрүүлэх бүр цаашаа." (До.Цэнджав, "Цаашаа"), "Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам, цэцэг нар хоёртоо бахардсан наадам, ижийтэй үзсэн тэр наадам, чихэр инээд хоёртоо бялуурсан наадам." (Б.Лхагвасүрэн) гэх мэтээр монголын орчин үеийн уран зохиолын найруулгад өргөн дэлгэр хэрэглэж байгаа нь дээрх жишээнүүдээс тодорхой байна.

Эдгээрийг шүлэг яруу найраг, найраглал зэрэгт байдаг толгой, сүүл холбон давтах хамгийн түгээмэл ур хийц гэж үздэг бөгөөд монгол аман зохиолын болон монголын орчин үеийн утга зохиолын баримтаас үзвэл иймэрхүү жишээ хэдэн зуугаар нь олж болно. Өөрөөр хэлбэл аман зохиолоос уламжлалтай ур хийц орчин үеийн утга зохиолд мөн уламжлагдах, үргэлжлэх, шингэх, давтагдах шинжтэй байна гэж үзэж болно.

Монгол хэлний давталтын онцлог юу вэ? Монгол хэлэнд үг давтахдаа ихэнхидээ хосоор буюу хоёроор давтдаг боловч цаашлаад гурав, дөрөв, тав хүртэл "үсэрч" дараалан давтах тохиолдол байгааг проф. Б.Пүрэв-Очир мөн ажигласан байна. Жишээ нь, "Атиран мяралзах Туулын боргионд ангир саран бутарч урсана, амраг минь, амраг минь, амраг минь гэсээр явтал аархаж явсан насны нар бууралтаж урсана." (Б.Лхагвасүрэн, "Насны урсгал"), "Юу ч биш, юу ч биш, юу ч бишийн дотор юм юм бий." (До.Цэнджав), "Найрын дууны цуурай хоносон талын намар оройн нуур газрын хөх пянз эргэлдэнэ, намар, намар, намар" (Б.Лхагвасүрэн, "Намрын нуурын сонат"), гэхэд гурав гурваар, "Далай далай гэвч далай далайдаа цутгадаггүй юм аа, дарс дарс гэвч, дарс дарсныхаа амтанд уусдаггүй юм аа." (До.Цэнджав, "Миний бодол") гэхэд дөрөв

25. Г.Галбаяр, 2012, "Монгол шүлгийн дунд холбоцын зарим онцлог", [Утга соёл судлал], Уб., 252-253 дах тал

дөрвөөр угсарсан бол, “Найгаад найгаад найгаад найгаад найгаад ганхахуйд насны жаалхан хонгор хүүгээ наадам болгонд санаад байна хө” гэхэд тав угсарч давтсан байх жишээтэй.

Монгол хэлний давталт өөр нэг сонин зүйл бол нэг өгүүлбэрт хоёроос дээш, хоорондоо ялгаатай өөр өөр хэдэн ч давталт орж болдог нэг боломж байдаг байна. Жишээлбэл, “Яндан хогир хогир хөдлөн, өрх сэв сэв хийн гэрийн гадаа элдэв юм савс савс хөдөлж эхлэв бололтой. Асар удсангүй яндан бүр чахар чахар савчиж, өрх ургаш хойш савж хаяагаар салхи хүүдийлэж хуугиж эхлэв.” (Б.Бааст, “Ногтруу”), “Нүүдэл нүүдэл үүлэнд нь саран тормолзож эрхэлнэ, нүгэл нүглийг мартан, нүд нүдэндээ эрхэлнэ.” (Б.Лхагвасүрэн, “Эрхлэхийн заяатай хорвоо”)

Өгүүлбэр нь тэр чигээрээ давталтаар бүтэх ч боломж монгол хэл найруулгад байна. Тухайлбал үүнийг хүүхдийн уран зохиолын төрөл бүрийн хэлбэр найруулгад их ашигласан байдаг. Жишээ нь: “Туулай туулай дэгдлээ дэгдлээ, тулаад тулаад ирлээ ирлээ. Бутанд бутанд бултгас бултгас, буцаад буцаад дэгдгэс дэгдгэс, араас нь араас нь хөөлөө хөөлөө, амьсгаадан амьсгаадан, гүйлээ гүйлээ, хаашаа хаашаа, жирийв ээ жирийв ээ, хаагуур хаагуур нуугдав аа нуугдав аа.” 3.Түмэнжаргал, “Туулай бид хоёр”

Монголын уран зохиолын бүх төрөл түүний дундаас хүүхдийн уран зохиолын найруулгад давтамал үгийг маш их хэмжээгээр хэрэглэдэг нь ажиглагдаж байна. Тухайлбал энд бид хүүхдийн уран зохиолын хамгийн түгээмэл сэдэв болох туулайн тухайн шүлгүүдэд түүний хөдөлгөөн, үйл, дүр төрх, байдлыг илэрхийлэх давтамал үгийн хэрэглээг төлөөлөл болгон цухас ажиглаж үзвэл энд дэлбэгэс дэлбэгэс, дэлдгэс дэлдгэс, дэгдгэс дэгдгэс, бүлтгэс бүлтгэс, бултгас бултгас, тонгос тонгос, бултан бултан, дэгдэн дэгдэн, бөг бөг, бөөн бөөн, бөн бөн, тайган тайган, бөмбөн бөмбөн, дэгдэн дэгдэн, сэртэн сэртэн, годос годос, дээр дээр, шөмбөс шөмбөс, бүлтэс бүлтэс, жирийх жирийх, гэх мэт давтамал үг хэллэгийг маш олон зохиолч өргөн ашигласан байх жишээтэй. Иймэрхүү давтамал үгийн сан энэ толь бичигт нэлээд хэсгийг эзэлж буйг энэ дашрамд дурдалтай.

Монгол оньсогын уран сайхан найруулгын хэв маягт давталтын үүрэг ба онцлог. Энэхүү номд орсон давтамал үг хэллэгийн нэлээд хэсэг нь оньсогын хэл найруулгад орсон давтамал үгийн сангаас бүрдэж байгаа юм. Тийм учраас бид монгол ардын оньсогын хэл найруулгад давтамал үгийн гүйцэтгэх үүрэг, онцлогийн талаар зарим ажиглалтаа энд дурдаж оруулах нь зүйтэй гэж үзсэн юм.

Монголын ард түмэн оюуны ухааны оньст тайлал болсон олон түмэн оньсогыг зохион, түүнийг үе дамжуулан хэлэлцэж, утга учрыг нь тайлж, тайлбарлаж ирсэн түүхтэй бөгөөд түүнийг судлаачид хэл, сэтгэлгээ, бүтэц, утга, найруулга зэрэг тал бүрээс нь нягтлан судалсаар байна.

Профессор Д.Галбаатар, “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл” нэвтэрхий толь бичигтээ, “Оньсого монголчуудын уран сайхны сэтгэлгээний абстракт чиглэлийн эртний төрөл юм. Оньсого хийсвэрлэн сэтгэх үйл ажиллагааны дээд түвшинд бодот ахуйг дуурайлгүй харин ч эвдэх, ондоошуулах аргаар оюуны хийсвэр ертөнц рүү хөтөлж, бодот ертөнцийн юмс үзэгдлийг өөрсдийн ахуй амьдралтай холбон хийсвэрлэх тусгай тайлал шаардаж, түүнийг дахин хийсвэрлэл болгон хувиргадаг өвөрмөц туурвил зүй юм.”²⁶ гэж оньсогын сэтгэлгээний онцлогийг тодорхойлсон бол “Оньсого бол ард түмний хурц ухаан, цэцэн оюун билгийн хүчээр юмыг урнаар тоочих, дүрслэх, илэрхийлэх, хийсвэрлэн сэтгэхийн гайхамшигтай үлгэр мөний учир уран сайхны олон талын арга хэрэглүүрийг ашиглаж зохиогдсон байдаг. Оньсогот юмс үзэгдлийн мөн чанарыг шууд илээр бус, утга далдалсан дүр дүрслэлээр гаргаж, заавал тайлал шаарддагаараа аман зохиолын бусад төрөл зүйлээс онцлог ялгаатай. Иймд оньсого нь юмыг тэр чигээр нь шууд бус ерөнхийд нь “хийсвэрлэн тусгаж, дүрслэлд хувирган шилжүүлж бүтээдэг байна.”²⁷ гэж аман зохиолын бусад төрлөөс ялгарах онцлогийг дурдсан байна.

26. Д.Галбаатар, 2012, “Уран зохиол, онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь”, Уб., 264 дэх тал;

27. Д.Галбаатар, 2001, “Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд”, Уб., 110 дах тал

Монгол оньсого дагнан судласан эрдэмтэн Г.Ловор, “Агуулгын хувьд байгаль, нийгмийн юм үзэгдлийн дотроос ... юм үзэгдлийн байдал төрх, байр орон, шинж чанар, үүрэг зориулалт гэх зэргийн адил төстэй талд түшиглэн нэгнийх нь нэрийг нууцлан, нөгөөгөөр нь төлөөлөмж болгон хошин ёгтоор шүлэглэж, хүний оюун билгийг шалгах, хариулт шаардсан аман зохиолын дүр дүрслэлт бичил төрөл зүйл гэж хэлж болно. Оньсого бол ямар нэг юм хийгээд үзэгдлийг хүний ой тойнд шингэм айзам хэмнэл бүхий уран ёгт цөөн үг бүхий шүлгийн хэллэгээр дүрсэлдэг учраас хүмүүст яруу найраг, хэл, гоо зүйн ойлголт өгөх бас нэг үүрэгтэй аман бүтээл юм.”²⁸ гэж тодорхойлжээ.

Монгол оньсогын бүтэц, утга, хэлний онцлогыг олон эрдэмтэн мөн судалж тэмдэглэж иржээ. Оньсогын тэрхүү хүний ой тойнд шингэм айзам хэмнэл бүхий уран яруу байгаагийн утга учир гагцхүү хэл найруулгад нь орших бөгөөд харин оньсогийн хэлний асуудлыг тусгайлан судлаагүй бөгөөд харин зарим эрдэмтэд уран сайхны асуудал хөндөхдөө дайвар маягтай дурдсан зүйлүүд бол бий. Тухайлбал эрдэмтэн Г.Ловор монгол оньсогоны уран сайхны онцлог, утга, учир зүйг судлан бичсэн нэгэн сэдэвт зохиолдоо оньсогын дүр дүрслэл, агуулга, хэлбэр, уран сайхны онцлог, бэлгэдэл тэргүүтнийг судалснаас гадна утга хэлний асуудлыг хөндөж гүнзгийрүүлэн судалж дүгнэхдээ бидний энд авч үзэн буй давталтын тухай ч ажиглан үзжээ. Тэрбээр, “Уг юмын хэсгийн бүтэц өнгө зүс, шинж тэмдгээр ижилдүү бол уг зүйлийг хүч нэмэгдүүлэх маягтай утга тодгүй үгээр давтан тухайлбал, зүү зүү шаргал, зүс нэг шаргал, бай бай шаргал, бас нэг шаргал (хамхуул), бай бай цагаан, байдаггүй шаргал, зүй зүй цагаан зүйдэлгүй цагаан (цаас) гэхчилэн нэгэн жигдийн юм гэсэн санааг гаргах жишээтэй.”²⁹ хэмээн дурджээ.

Монгол оньсогын хэлний хэрэглүүрийг нарийн сайн ажиглавал авиа дууриах болон дүрслэх үгээр бүтсэн давтамал үг нь түүнийг бүтээх гол түүхий эд болдог байна. Тийм учраас энэ номд давтамал үг хэллэгийн жишээ болсон маш олон оньсого багтаж орсон бөгөөд тэдгээрийн утга чанарыг ажиглавал ихэнхи нь аливаа хүн амьтан болоод юмын үйл хөдөлгөөнийг илэрхийлсэн (бөмбөө бөмбөө, бөн бөн, бувар бувар, бугдас бугдас, бултан бултан, бушуу бушуу, гагар гагар, гилжин гилжин, годор годор, годос годос, гозго гозго, гуйван гуйван, гулжин гулжин, гулс гулс, гунхан гунхан, гүдэн гүдэн, гэлэр гэлэр, дагар дагар, дэг дэг, ёдор ёдор, живэр живэр, жийвэн жийвэн, жийг жийг, жирэн жирэн, жовон жовон, зэвэн зэвэн, идээд идээд, лав лав, лагар лагар, лэг лэг, мидар мидар, моожинхон моожинхон, мээгэр мээгэр, мятар мятар, найга найга, нам нам, нислээ нислээ, ноог ноог, гэх мэт), дуу чимээг илэрхийлсэн (бүм бүм, бүүр бүүр, вааг вааг, ваар ваар, гангар гангар, гоог гоог, гос гос, гохин гохин, гөд гөд, хүд хүд, гуа гуа, гуваа гуваа, гуд гуд, гун гун, гүд гүд, дон дон, дэр дэр, ёо ёо, жав жав, жангар жангар, жин жин, жингэр жингэр, ин ин, маа маа, майг майг, миаг миаг, нир нир, гэх мэт), хэмжээ дамжааг илэрхийлсэн (бууран бууран, гур гур, гургаа гургаа, давхар давхар, лог лог, луг луг, гэх мэт), тоо хэмжээг заасан (гучин гучин, далан далан, дош дош, мянга мянга, түм түм, наян наян, гэх мэт), дүр байдлыг илтгэсэн (бөртөн бөртөн, бэдэр бэдэр, гүдгэр гүдгэр, занги занги, зэрэг зэрэг, гэх мэт), өнгө зүсийг тодруулсан (буур буур, гялав гялав, гялан гялан, жарав жарав, жирс жирс гэх мэт), хэлбэр дүрсийг илэрхийлсэн (бүдэр бүдэр, гэх мэт), нэр нэршил болж тодотгосон (будaa будaa, бурхан бурхан, дүүдий дүүдий, дэлүү дэлүү, мич мич, могой могой, муруй муруй, найр найр, гэх мэт) зэрэг олон зүйл хэлбэрийг ашиглан оньсогыг уран сайхны хувьд уран яруу болгохоос гадна сэтгэлгээний хувьд тогтооход хялбар, тухайн зүйлийг илүү амар хурдан таньж мэдэх боломж олгодог гэж үзэж болохоор байна. Энэ нь аливаа давталт бол ой тогтоолтод нөлөөлж байдагтай холбоотой юм.

Учир нь ийнхүү давтаж хэлсэн зүйл бол хүний ялангуяа хүүхдийн оюун ухаанд амархан тогтох бөгөөд тухайн зүйлийн дүр дүрслэлийг тогтоох, хялбар хурдан таньж мэдэж ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

28. Г.Ловор, 2005, “Монгол оньсогын уран сайхны онцлог, утга, учир зүй”, Уб., 23 дах тал

29. Г.Ловор, 2005, “Монгол оньсогын уран сайхны онцлог, утга, учир зүй”, Уб., 119 дэх тал

Жишээлбэл монгол оньсогот оролцсон үгийн бүрэлдэхүүнийг харвал хүмүүсийн сайн мэдэх, өдөр тутмын амьдралд тохиолддог алд алд, алцага алцага, ангас ангас, баахан баахан, бар бар, биш биш, бөвөг бөвөг, бөг бөг, бур бур, год год, гүдэн гүдэн, дэгдэн дэгдэн, ёрдого ёрдого, жарав жарав, жир жир, зөв зөв, нам нам, нэмэн нэмэн, орилон орилон, өөвөн өөвөн, пур пур, гэх мэт давтмал үг их байхаас гадна өдөр тутам хэрэглэгддэггүй, толь бичигт байдаггүй, бараг зөвхөн оньсогын хэл найруулгат л байдаг болов уу гэмээр агдар агдар, байл байл, бахаг бахаг, бөөг бөөг, бунтан бунтан, бээжир бээжир, гагар гагар, ганж ганж, горгой горгой, гөмбөр гөмбөр, гэлэр гэлэр, гээнэ гээнэ, даадар даадар, дөөдэй дөөдэй, дүүдий дүүдий, жаргай жаргай, жийл жийл, жөвөн жөвөн, зэвэн зэвэн, иглэр иглэр, лар лар, маахар маахар, мидар мидар, мэгэр мэгэр, мээг мээг, мяаг мяаг, наг наг, ноог ноог, нягар нягар, олон давтмал үг хэллэг байх бөгөөд эдгээрийн ихэнхи нь тайлбар толь бичигт байдаггүй учраас утгыг тайлж мэдэхэд зарим бэрхшээл гардаг байна. Үүнийг чухам монгол хүний сэтгэлгээгээр тухайн амьтан юмын хөдөлгөөний байдал, өгүүлбэр, үг хэллэгийн өнгө аясаас нь ажиглан түүнтэй уялдуулан утгыг тайлж ойлгох бөгөөд харин түүнийг тэр бүр тайлбарласан жишээ баримт бид олж чадсангүй.

Ийнхүү монгол оньсогын хэл найруулгын гарцаагүй нэгэн сонин хэв маяг нь давтмал үг хэллэг мөн болох нь бидний цуглуулсан жишээ баримтаас тодорхой бөгөөд дээрх үг хэллэгүүдээс ажиглавал аливаа амьтан хүн юмын дуу авиаг илэрхийлсэн үг хэллэг их байгаа нь дуу авиагаар аливаа зүйлийг дүрслэн үзүүлэх ур маягыг оньсогот ихээхэн ашигладаг болох нь харагдаж байна. Үүнийг профессор Б.Пүрэв-Очир мөн ажиглаж, "... ихэвчлэн дуу чимээний үг ба дүрслэх үгийн язгуурыг эс өөрчлөн давтан хэрэглэсэн нь элбэг байдаг. Ерөөс дуу чимээний үг, дүр байдал заах дүрслэх үгс нь язгуураараа өөрөө давтагдаж байж, тэрхүү дуу чимээний болон дүрслэх утгаа илүү тодорхой үзүүлж байдаг зүй тогтолтой шиг байна."³⁰ хэмээн бичжээ.

Монгол ардын аман зохиолын бусад хэлбэр түүний дотор шүлэглэсэн хэлбэрүүдийн найруулгын өнгө аяс, хэв маягийг ажиглавал оньсогоос бусдад нь тэр болгон давтмал үг хэллэг бараг хэрэглэдэггүй бөгөөд хэвшмэл хэллэгт хаа нэгтээ (Хумсалсаар хумсалсаар хулгайч, хуурсаар хуурсаар хулгайч, гэх мэт) тохиолдохоос биш бараг олоход бэрхтэй байдаг. Тийм учраас давтмал үг хэллэг бол монгол оньсого бүтээх хэл зүй, үгийн сан утга зүйн нэгэн зүйл өвөрмөц хэв маяг гарцаагүй мөн гэж тодорхойлж болох юм.

Дүгнэхэд монгол хэлний давтмал үг бол бусад гадаад хэлний нэгэн адил бүрэн ба бүрэн бус гэсэн хэлбэртэй, голлон хэлний зүйн утга илэрхийлэх үүрэг гүйцэтгэх, уран зохиолын төрөл бүрийн найруулга тэр дундаа аман зохиол, оньсого, хүүхдийн зохиолын найруулгад өргөн дэлгэр хэрэглэгддэг хоршоо үгээс огт ялгаатай, үгээс өгүүлбэр хүртэл төвшинд байж болдог хэлний бие даасан үзэгдэл мөн болох нь тодорхой байна.

30. Б.Пүрэв-Очир, 1998, "Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, тэдгээрийн бүтэц, хэвшинж, утга, үүрэг", [Монгол хэлний өгүүлбэрзүй Уб.,] 92 дах тал